



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ



World Health
Organization
Western Pacific Region

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТООЦОО 2016-2022

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

Энэхүү эмхэтгэлийн талаарх саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

Эрүүл мэндийн хөгжлийн төв

Эрүүл мэндийн эдийн засаг бодлогын судалгааны алба

Шуудангийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот – 210648, Ш/Х-187, Сүхбаатар Дүүрэг,
1-р хороо, Энхтайвны гудамж -13Б

Факс: 976-11-320633

Утас: 70128807

Цахим шуудан: emezbsa@hdc.gov.mn

Цахим хуудас: www.hdc.gov.mn

Эрхэлсэн: Б.Нарантуяа, ЭМХТ-ийн захирал

Хянасан: С.Мөнхсүх, ЭМЭЗБСА-ны дарга

Наталья Эйго, ДЭМБ-ийн ЗӨАНДБ-ийн зөвлөх

Фе Вида, ДЭМБ-ийн ЗӨАНДБ-ийн зөвлөх

Эмхэтгэсэн: Ц.Болормаа, ЭМЭЗБСА-ны ахлах мэргэжилтэн

Ж.Ундрал, МТА-ны мэргэжилтэн

Ч.Мичидмаа, ЭМЭЗБСА-ны ахлах мэргэжилтэн

Э.Хонгорзул, ЭМЭЗБСА-ны мэргэжилтэн

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	v
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	vi
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	vii
ӨМНӨХ ҮГ	viii
ТОВЧ ХУРААНГУЙ	ix
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	xii
БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1 Эрүүл мэндийн нийт зардал	1
1.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь.....	3
1.3 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал	6
1.4 Эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь.....	7
БҮЛЭГ II. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН АНГИЛАЛ	12
2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр	12
2.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал.....	13
2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн ангилал.....	15
2.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төрлөөр	17
2.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ангиллаар.....	21
2.6 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгийн зардлын ангилал.....	23
2.7 Эрүүл мэндийн зардал газар зүйн байршлаар	25
БҮЛЭГ III. ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ	27
3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь.....	27
3.2 Эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь.....	29
3.3 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал	30
ДҮГНЭЛТ / ХЭЛЦЭМЖ	34
ХАВСРАЛТ.....	35
<i>Хавсралт хүснэгт 1. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2016 он.....</i>	36
<i>Хавсралт хүснэгт 2. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2017 он.....</i>	37
<i>Хавсралт хүснэгт 3. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2018 он.....</i>	38
<i>Хавсралт хүснэгт 4. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2019 он.....</i>	39

Хавсралт хүснэгт 5. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2020 он.....	40
Хавсралт хүснэгт 6. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2021 он.....	41
Хавсралт хүснэгт 7. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт болон орлогын эх үүсвэрээр 2022 он.....	42
Хавсралт хүснэгт 8. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2016 он	43
Хавсралт хүснэгт 9. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2017 он	45
Хавсралт хүснэгт 10. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2018 он	47
Хавсралт хүснэгт 11. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2019 он	49
Хавсралт хүснэгт 12. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2020 он	51
Хавсралт хүснэгт 13. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2021 он	53
Хавсралт хүснэгт 14. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон санхүүжилтийн ангиллаар 2022 он	55
Хавсралт хүснэгт 15. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2016 он	57
Хавсралт хүснэгт 16. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2017 он	58
Хавсралт хүснэгт 17. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2018 он	59
Хавсралт хүснэгт 18. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2019 он	60
Хавсралт хүснэгт 19. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2020 он	61
Хавсралт хүснэгт 20. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2021 он	62
Хавсралт хүснэгт 21. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн ангиллаар 2022 он	63
Хавсралт хүснэгт 22. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2016 он.....	64
Хавсралт хүснэгт 23. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2017 он.....	65
Хавсралт хүснэгт 24. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2018 он.....	66

Хавсралт хүснэгт 25. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2019 он.....	67
Хавсралт хүснэгт 26. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2020 он.....	68
Хавсралт хүснэгт 27. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2021 он.....	69
Хавсралт хүснэгт 28. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангиллаар 2022 он.....	70
Хавсралт хүснэгт 29. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2016 он	71
Хавсралт хүснэгт 30. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2017 он	72
Хавсралт хүснэгт 31. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2018 он	73
Хавсралт хүснэгт 32. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2019 он	74
Хавсралт хүснэгт 33. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2020 он	76
Хавсралт хүснэгт 34. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон зардлын ангиллаар 2021 он	77
Хавсралт хүснэгт 35. Эрүүл мэндийн зардал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч Байгууллага болон зардлын ангиллаар 2022 он.....	78

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.1 Эрүүл мэндийн нийт зардал	1
Зураг 1.1.2 Эрүүл мэндийн нийт зардлын бүтэц, хувиар.....	2
Зураг 1.2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь.....	3
Зураг 1.2.2 Эрүүл мэндийн зардлын бүтэц, тэрбум төгрөг.....	4
Зураг 1.3.1 Нэг хүнд ногдох ДНБ ба эрүүл мэндийн зардал	6
Зураг 1.4.1 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь	7
Зураг 2.1.1 Эрүүл мэндийн зардалд орлогын эх үүсвэрийн эзлэх хувь	12
Зураг 2.2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал (хувиар).....	13
Зураг 2.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бүтэц (хувиар) ...	15
Зураг 2.4.1 Эрүүл мэндийн зардал, тусламж, үйлчилгээ эрхлэгч байгууллагаар (хувиар)	17
Зураг 2.5.1 Эрүүл мэндийн зардал тусламж, үйлчилгээний ангиллаар, (хувиар)	21
Зураг 2.6.1 Хөрөнгийн зардал дэд ангиллаар (хувиар)	23
Зураг 2.6.2 Хөрөнгийн зардал дэд ангиллаар (тэрбум төгрөгөөр).....	24
Зураг 2.7.1 Эрүүл мэндийн зардал газар зүйн байршилаар (хувиар).....	25
Зураг 3.1.1 ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь; бүс нутгаар, орлогын бүлгээр....	27
Зураг 3.1.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь.....	28
Зураг 3.2.1 Эрүүл мэндийн урсгал зардалд хувийн төлбөрийн эзлэх хувь	29
Зураг 3.3.1 Нэг хүнд ноогдох Эрүүл мэндийн урсгал зардал (ам.доллар тухайн жилийн дундаж ханшаар тооцсон)	30
Зураг 3.3.2 ДЭМБ-ын бүс нутаг, Дэлхийн банкны орлогын бүлэг, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Нэг хүнд ноогдох Эрүүл мэндийн зардал (ам.доллар)	31
Зураг 3.3.3 Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүсийн орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эрүүл мэндийн зардлын хувь ба нэг хүнд ноогдох эрүүл мэндийн зардал, 2021 он	32
Зураг 3.3.4 ДЭМБ-ын бүс нутаг, Дэлхийн банкны орлогын бүлэг, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эрүүл мэндийн зардлын хувь ба нэг хүнд ноогдох эрүүл мэндийн зардал, 2021 он	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1.2.1 Эрүүл мэндийн зардал ба Дотоодын нийт бүтээгдэхүүн, тэдгээрийн жилийн өсөлт.....</i>	<i>4</i>
<i>Хүснэгт 1.3.1 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал.....</i>	<i>6</i>
<i>Хүснэгт 1.4.1 Үндсэн үзүүлэлтүүд.....</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 2.1.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрээр</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 2.2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал (хувиар).....</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 2.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн ангилал (тэрбум төгрөг)</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 2.4.1 Эрүүл мэндийн зардал, байгууллагын төрлөөр (тэрбум төгрөг)</i>	<i>18</i>
<i>Хүснэгт 2.4.2 Эрүүл мэндийн зардал, байгууллагын төрлөөр (хувиар)</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 2.5.1 Эрүүл мэндийн зардал тусламж, үйлчилгээний ангиллаар (тэрбум төгрөг)</i>	<i>22</i>
<i>Хүснэгт 2.6.1 Хөрөнгийн зардал дэд ангиллаар (тэрбум төгрөг).....</i>	<i>24</i>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗӨАНДБ	Зүүн Өмнөд Ази Номхон Далайн Баруун Бүс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМҮТ	Эрүүл мэндийн үндэсний тооцоо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв

ӨМНӨХ ҮГ

Эрүүл мэндийн үндэсний тооцоог анх Монгол улсад олон улсын жишгээр тооцох ажил 2002-2005 онд Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр төслийн хүрээнд хийгдэж, улмаар 2005 онд Эрүүл мэндийн сайдын 254 тоот тушаалын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн Статистик Мэдээллийн албаны бүтцэд эрүүл мэндийн үндэсний тооцооны асуудал хариуцсан нэгжийг байгуулсан түүхтэй. Цаашлаад 2003-2014 оныг хамарсан нийт 12 жилийн тооцооллыг 2014 оноос боловсруулж эхэлсэн ба үр дүнг 2017 онд танилцуулж байсан бол 2015 оны Эрүүл мэндийн үндэсний тооцоог 2019 онд танилцуулж байсан.

Энэ удаагийн тооцооллоор Эрүүл мэндийн үндэсний тооцоог 2016-2022 оныг хамран боловсруулсан ба эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардлын мэдээллийг цуглуулан, нэгтгэж олон улсын “Эрүүл мэндийн тооцооны систем 2011” (System of Health Accounts 2011) аргачлалын дагуу тооцон та бүхэнд өргөн барьж байна.

Эрүүл мэндийн үндэсний тооцоог боловсруулахад бидэнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд хамтран ажилласан Эрүүл Мэндийн Яам, Сангийн Яам, Үндэсний Статистикийн Хороо, Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар, Татварын Ерөнхий Газар, эрүүл мэндийн салбарын бүх түвшний төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, техникийн туслалцаа үзүүлж хамтран ажилласан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Эрүүл мэндийн үндэсний тооцоо нь олон улсын түвшинд эрүүл мэндийн бодлогыг тодорхойлох чухал хэрэгсэл болдог бөгөөд шийдвэр гаргагчдад бодлого боловсруулах, бодлогын өөрчлөлтийн үр нөлөөг хянах, зардлын чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой нотолгоот мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
АНАГААХ УХААНЫ ДОКТОР Б.НАРАНТУЯА

ТОВЧ ХУРААНГУЙ

Эрүүл мэндийн үндэсний тооцоо гэж юу вэ?

Эрүүл мэндийн үндэсний тооцоо /ЭМҮТ/ нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эх үүсвэр, чиг үүрэг, үйлчилгээ үзүүлэгчээр нь цогц байдлаар бүртгэдэг бүртгэлийн тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн салбарын санхүүгийн нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, түүний зарцуулалттай холбоотой мэдээллийг олон улсын стандарт ангиллын дагуу цогц байдлаар бүртгэн зардлын урсгалыг хянах систем юм.

Монгол улсын ЭМҮТ-ны үндсэн үзүүлэлтүүд ямар байсан бэ?

Эрүүл мэндийн зардал 2016-2022 оны хооронд тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа ба 2016 онд 1,096 тэрбум төгрөгийг эрүүл мэндэд зарцуулсан бол 2022 онд энэ үзүүлэлт 4.3 дахин нэмэгдэж 4,767 тэрбум төгрөгт хүрч өссөн байна.

Эрүүл мэндийн зардалд 2016-2020 он хүртэл дунджаар улсын эрүүл мэндийн байгууллагуудын зардал 43 хувийг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал 36 хувийг эзэлдэг байсан бол 2021-2022 онд улсын эрүүл мэндийн байгууллага болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад гарсан зардал тус тус 38 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. (зураг 1.1.2)

Харин дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2016-2020 онд дунджаар 4.5 хувь буюу 4.3-4.7 хувийн хооронд харьцангуй тогтвортой байсан. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эрүүл мэндийн зардал нэмэгдсэн нь энэхүү үзүүлэлтэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн, тухайлбал 2021 онд 2.5 нэгж хувиар нэмэгдэж 7.2 хувь, 2022 онд 8.9 хувьд хүрч өссөн байна. Тухайлбал төрөөс санхүүжүүлсэн эрүүл мэндийн зардлын ДНБ-д эзлэх хувь 2016-2020 онд 2.1-2.6 хувийг эзэлж ирсэн бол 2021 онд энэ үзүүлэлт нэмэгдэж 4.2 хувьд хүрсэн ба 2022 онд өмнөх оноос 1.1 нэгж хувиар буурч 3.1 хувьд хүрсэн байна. Харин эрүүл мэндийн зардалд төрөөс санхүүжүүлсэн зардлын хувь 2016-2020 онуудад 56-46 хувийг эзэлж ирсэн бол 2021 онд энэ үзүүлэлт өсөж 58.4 хувьд хүрсэн ба 2022 онд 35 хувьд хүрч буурсан үзүүлэлттэй байна.

Мөн нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 2016 онд 351 мянган төгрөг байсан бол 2022 онд 4 дахин өсөж 1.38 сая төгрөгт хүрсэн байна. Хувийн төлбөрийн хэмжээ 2016-2018 онд 35-аас 44 хувьд хүрч өссөн ба 2019-2020 онд тогтмол буюу 43 хувь, 2021 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөл хорио тогтоосонтой холбоотой буурч 31 хувьд хүрсэн хэдий ч 2022 онд 39 хувьд хүрч өссөн үзүүлэлттэй байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээнд 2016-2019 онд дунджаар эрүүл мэндийн зардлын 13 орчим хувийг зарцуулдаг байсан бол 2020-2021 онд цар тахлын нөлөөгөөр энэ үзүүлэлт нэмэгдэж 17-20 хувьд хүрсэн. 2022 онд 7 хувьд хүрсэн нь өмнөх оноос мөнгөн дүнгээр 6.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Анхан шатны тусламж, үйлчилгээ¹-ний эрүүл мэндийн зардалд эзлэх хувийн жин буурахад эрүүл мэндийн зардалд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад гарсан зардал болон хандивлагч байгууллагаас зарцуулсан зардлын хувийн жин нэмэгдсэн нь нөлөөлжээ.

¹ Эрүүл мэндийн тухай хууль 3.1.24

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэн санхүүжүүлсэн бэ?

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 2016-2020 оны дунджаар улсын төсөв 31.2 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 20.2 хувь, өрх хувь хүний төлбөр 40.6 хувь, сайн дурын болон гадаад эх үүсвэрийн санхүүжилт 8.1 хувийг тус тус эзэлж байсан.

Эрүүл мэндийн салбарт санхүүгийн шинэчлэлт хийхээс өмнөх жилүүдэд эрүүл мэндийн зардалд улсын төсвийн санхүүжилт голлох үүрэг гүйцэтгэж ирсэн ба 2020 онд эрүүл мэндийн зардлын 35.4 хувийг санхүүжүүлсэн. Улмаар 2021 онд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд улсын төсвийн санхүүжилт 13.5 хувь, 2022 онд 3.5 хувьд хүрч буурсан байна. Харин 2020 онд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 18.7 хувь байснаас 2021 онд 45.7 хувь хүртэл нэмэгдэж, 2022 онд 31.8 хувьд хүрч буурсан хэдий ч мөнгөн дүнгээр өмнөх оноос 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өрх, хувь хүний төлбөр буюу халааснаас гарах төлбөрийн хэмжээ 2016-2021 онд мөнгөн дүнгээр жилд дунджаар 21 хувиар өссөн ба эрүүл мэндийн зардлын 35-43 хувийг санхүүжүүлэх болсон. Улмаар 2021 онд цар тахлын нөлөөгөөр хөл хорио тогтоосонтой холбоотой халааснаас гарах төлбөрийн хэмжээ буурч 31 хувьд хүрсэн хэдий ч 2022 онд эргээд 39 хувь болтол өссөн байна. Гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн хувьд 2020 онд 2 хувь байсан бол 2021 онд 9 хувьд хүрч, 2022 онд 24 хувьд хүрч өссөн байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэн үзүүлсэн бэ?

Эрүүл мэндийн зардлыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч *байгууллагын төрлөөр* авч үзвэл 2016-2022 оны дунджаар дараах байдлаар зарцуулагдсан байна. Үүнд:

- Бүх төрлийн ортой эмнэлэг болох төрийн болон хувийн хэвшлийн ортой эмнэлэг – 45.8 хувь;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэгчид болох эмийн сан, эм ханган нийлүүлэх төв, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх байгууллага – 26.2 хувь;
- Удирдах байгууллагууд болох ЭМЯ болон харьяа агентлаг, төвүүд, аймаг, нийслэлийн ЭМГ – 5.6 хувь;
- Амбулаторийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага- 4.7 хувь;
- Туслах үйлчилгээ эрхлэгч болон урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага- 1.3 хувь;
- Урт хугацааны тусламж, үйлчилгээ эрхлэх байгууллагууд болох сэргээн засах төв болон рашаан сувиллын үйлчилгээ эрхлэгч байгууллагууд гарсан зардал 1.2 хувь;
- Бусад буюу хандивлагч байгууллагууд, гадаадад эмчилгээ хийлгэсэн иргэдийн зардал – 11.5 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн санхүүжилтийг ямар тусламж, үйлчилгээнд зарцуулсан бэ?

Эрүүл мэндийн зардлыг *тусламж, үйлчилгээний ангиллаар* авч үзвэл 2016-2022 оны дунджаар дараах байдлаар зарцуулагдсан байна. Үүнд:

- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд - 25.2 хувь;
- Амбулаторийн тусламж, үйлчилгээнд - 19.5 хувь;
- Эм, эмнэлгийн хэрэгсэлд - 26.0 хувь;
- Туслах үйлчилгээнд (дүрс оношилгоо, лаборатори, түргэн тусламж) - 6.4 хувь;
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд - 5.6 хувь;

- Төрийн болон эрүүл мэндийн удирдлагаар хангах үйл ажиллагаанд - 4.7 хувь;
- Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээнд - 2.0 хувь;
- Өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээнд - 1.5 хувь;
- Сэргээн засах тусламж, үйлчилгээнд - 1.3 хувь;
- Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээнд - 1.1 хувийг тус тус зарцуулсан байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн үндэсний тооцоо /ЭМҮТ/ нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эх үүсвэр, чиг үүрэг, үйлчилгээ үзүүлэгчээр нь цогц байдлаар бүртгэдэг бүртгэлийн тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн салбарын санхүүгийн нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, түүний зарцуулалттай холбоотой мэдээллийг олон улсын стандарт ангиллын дагуу цогц байдлаар бүртгэн зардлын урсгалыг хянах систем юм. Эрүүл мэндийн зардлыг системтэйгээр хянаснаар үндэсний хэмжээнд бодлого боловсруулалт; бодлогын өөрчлөлтийн үр нөлөөг дүгнэх; зардлын чиг хандлагыг бүрэн хянах боломжийг олгодог.

Ангилал

Монгол улсын Санхүү, Эдийн Засгийн Сайд, Эрүүл Мэндийн Сайд, Үндэсний Статистикийн Газрын даргын хамтарсан 226/193/157 дугаар тушаалын дагуух үндсэн 3 ангилал (HF- санхүүгийн эх үүсвэр, HP- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, HC-тусламж, үйлчилгээний төрөл), Эрүүл мэндийн тооцооны систем 2011 аргачлалын дагуу нэмэлтээр 4 ангилал (FSRI-орлогын эх үүсвэр, FS-санхүүжүүлэх орлого, НК-хөрөнгийн ангилал, SNL-газар зүйн байршил)-аар тооцоолсон.

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал (HF) нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид төлбөр **аль эх үүсвэрээс орж, хаагуур дамжуулан хуваарилагдаж** байгааг харуулна. Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сан; сайн дурын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөр (сайн дурын даатгал, ашгийн бус байгууллагын санхүүжилт, аж ахуй нэгж байгууллагын санхүүжилт); өрх хувь хүний төлбөр; гадаад эх үүсвэрийн санхүүжилт; бусад ангилагдаагүй гэх хэсгүүдээс бүрдэнэ.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ангилал (HC) нь **ямар тусламж, үйлчилгээнд** эрүүл мэндийн зардал зарцуулагдаж буйг тусламж, үйлчилгээний төрлөөр задлан харуулдаг. Тус ангилал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ; сэргээн засах тусламж, үйлчилгээ; урт хугацааны тусламж, үйлчилгээ; туслах үйлчилгээ; эм эмнэлгийн хэрэгсэл; урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ; санхүүгийн удирдлага болон бусад гэсэн ангиллуудаас бүрдэнэ.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ангилал (HP) нь **аль нийлүүлэгчээр дамжин** тусламж, үйлчилгээний зардал **хаана зарцуулагдаж байна вэ** гэдгийг харуулах бөгөөд эмнэлэг, урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, туслах үйлчилгээ үзүүлэгч байгууллага, жижиглэн худалдаа эрхлэгч болон эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэгч байгууллага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, санхүүжилт, бусад, гадаадын байгууллага, ангилагдаагүй гэх ангиллуудаас бүрдэнэ.

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийн ангилал (FSRI) нь эрүүл мэндийн зардал **хаанаас** гарсныг засгийн газар; аж ахуй нэгж; өрх хувь хүн; ашгийн бус байгууллага болон хандивлагчаар задлан харуулдаг.
- Эрүүл мэндийн, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал (FS) нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад санхүүжилт **ямар хэлбэрээр** орж ирснийг улсын төсвийн шилжүүлэг, гадаад эх үүсвэртэй санхүүжилтийг улсаас хуваарилсан шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, заавал төлөх урьдчилсан төлбөр.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгийн зардлын ангилал (НК) нь тухайн жилд худалдаж авсан хөрөнгийн зардлыг хөрөнгийн төрлөөр ангилан харуулдаг. Үүнд: дэд бүтэц; машин тоног төхөөрөмж; оюуны өмчөөр баталгаажсан бүтээгдэхүүн; их засвар зэргээр ангилан харуулдаг.
- Эрүүл мэндийн зардал газар зүйн байршлын ангилал (SNL) нь эрүүл мэндийн зардал **хаана** гарч буйг газар зүйн байршлаар буюу аймаг хот, бүс нутгаар ангилан харуулдаг.

Тооцоололд ашигласан мэдээллийн хүрээ

Энэхүү тооцоололд Монгол улсын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, гадаад дотоодын хандивлагчид болон төрийн бус байгууллагуудаас эрүүл мэндийн чиглэлээр зарцуулсан зардал болон гадаадад эмчлүүлсэн иргэдийн эмчилгээнд зарцуулсан зардлыг хамрууллаа. Цаг үеийн нөхцөл байдал болон мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2020-2022 оны тооцоололд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй Төрийн бус байгууллагуудын мэдээлэл болон 2016-2022 оны эрүүл мэндтэй холбоотой халамж тэтгэмжийн зардлыг тооцоололд хамруулаагүйг анхаарна уу.

Тооцоололд ашигласан үндсэн мэдээлэл

Улсын эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл:

- Сангийн яам, Эрүүл мэндийн яам “Төсвийн гүйцэтгэлийн тайлан”, 2016-2022 он
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, “Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын тайлан”, 2016-2022 он
- Үндэсний аудитын газар, “Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”, 2016-2022 он
- Бүх шатны эмнэлгүүдээс авсан өртгийн мэдээлэл, 2016-2022 он

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл:

- Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан А-ЭМТ-6 маягтаар улирлын мэдээ, 2016-2022 он
- Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1/161 тоот тушаалаар баталсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээний маягт (ААНБ-2) жилийн эцсийн мэдээ, 2016-2022 он
- Татварын ерөнхий газраас авсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын орлого, зарлагын мэдээ, 2016-2022 он
- Санхүүгийн зохицуулах хороо, “Даатгалын салбарын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулга”, 2016-2022 он
- Хувийн даатгалын байгууллагуудын зардлын мэдээлэл, 2016-2022 он

Хандивлагч байгууллагуудын мэдээлэл:

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хандивлагчдын зээл, тусламжийн талаарх мэдээллийн сан
- Хандивлагч байгууллагуудын үйл ажиллагааны нэгдсэн тайлангууд
- Эрүүл мэндийн яам, Хандивлагч байгууллагын нэгдсэн бүртгэл, 2021-2022 он

Төрийн бус байгууллагын зардлыг тооцоход ашигласан үндсэн мэдээллүүд:

- Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Төрийн бус байгууллагуудад хийсэн зардлын судалгаа” 2016-2019 он

Гадаадад эмчлүүлэгчдийн зардлыг тооцоход ашигласан үндсэн мэдээлэл:

- Монгол банкны төлбөрийн тэнцлийн тооцоо, 2016-2022 он

- Эрүүл мэндийн яамнаас зайлшгүй шаардлагаар (МУ-д эмчлэх боломжгүй өвчний жагсаалт²ад орсон) гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн мэдээлэл, 2016-2022 он
- Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Гадаадад эмчлүүлэгчдийн зардлын судалгаа” 2019
- Эрүүл мэндийн яам, Монгол банк, Эрүүл мэндийн хөгжлийн төв “Гадаад улсад эмчлүүлсэн Монгол иргэдийн зардлын судалгаа” 2020 он

Бусад:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд
- Үндэсний статистикийн хороо, Статистик мэдээллийн нэгдсэн сан болон 2016-2022 оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” болон “Ажиллах хүчний судалгаа”-ны мэдээллийн сан.

Тооцооллын аргачлал

Монгол улсын 2016-2022 оны Эрүүл мэндийн үндэсний тооцоог Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан “Эрүүл мэндийн тооцооны систем-2011” стандартаар “Health account production tool SHA 2011” 4.0.0.6 программаар боловсрууллаа.

Тайлан нь: I. эрүүл мэндийн зардлын үндсэн үзүүлэлтүүд II. эрүүл мэндийн зардлын ангилал III. Олон улсын харьцуулалт гэсэн гурван үндсэн бүлэгтэй ба хэмжээс хоорондын хамаарлыг харуулах хүснэгтүүдийг хавсралтаар оруулсан.

Хязгаарлагдмал байдал

Цаг үеийн нөхцөл байдал болон мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2020-2022 оны тооцоололд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй Төрийн бус байгууллагуудын мэдээлэл болон 2016-2022 оны эрүүл мэндтэй холбоотой халамж тэтгэмжийн зардлыг тооцоололд хамруулаагүйг анхаарна уу.

² Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан “Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-д 26 өвчин багтдаг ба Эрүүл мэндийн яамнаас эдгээр жагсаалтад орж, гадаадад эмчилгээ авсан иргэдэд нэг удаад 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгодог.

БҮЛЭГ I.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 Эрүүл мэндийн нийт зардал

Монгол улсын хүн ам зүй болон нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын улмаас эрүүл мэндийн зардал тогтмол өсөж ирсэн. 2016-2020 онд жилийн дундаж өсөлт 10 хувь байсан. Харин эрүүл мэндийн салбарын шинэчлэл, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахал, цаг үеийн эдийн засгийн хямралт нөхцөл байдлаас шалтгаалсан инфляцын нөлөөгөөр 2021 онд өмнөх оноос 1.6 дахин өсөж 3.1 их наяд төгрөгт хүрсэн, 2022 онд өмнөх оноос 1.5 дахин өсөж 4.7 их наяд төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 1.1.1 Эрүүл мэндийн нийт зардал




Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Эрүүл мэндийн нийт зардалд 2016-2020 он хүртэл дунджаар улсын эрүүл мэндийн байгууллагуудын зардал 43.4 хувийг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал 36.0 хувийг эзэлдэг байсан бол 2021-2022 оны дунджаар улсын эрүүл мэндийн байгууллага болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал тус тус 38 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Цаашид эрүүл мэндийн нийт зардалд улсын эрүүл мэндийн байгууллагын зардлын эзлэх хувь буурч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардлын хувийн жин нэмэгдэх зүй тогтол ажиглагдаж байна.

Гадаадад эмчлүүлсэн иргэдийн зардал 2016-2020 онд дунджаар нийт зардлын 7.2 хувийг эзэлдэг байсан бол 2021 онд цар тахлын нөлөөгөөр буурч 1.4 хувьд хүрсэн боловч 2022 онд өсөж 7.1 хувьд буюу 343.7 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хандивлагч байгууллагуудаас эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр болон санхүүжүүлсэн зардлын хэмжээ нь 2016-2020 онд дунджаар нийт зардлын 3 хувийг эзэлж ирсэн бол 2021-2022 онд энэ үзүүлэлт нэмэгдэж дунджаар 16.5 хувьд хүрсэн байна.

Зураг 1.1.2 Эрүүл мэндийн нийт зардлын бүтэц, хувиар




Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

1.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь

Тухайн улсын эрүүл мэндийн салбарт хуваарилж буй нөөц нь нийт эдийн засгийн хэмжээтэй харьцуулахад ямар түвшинд байгааг энэ үзүүлэлтээр тодорхойлдог. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2016-2020 онд дунджаар 4.5 хувь буюу 4.3-4.7 хувийн хооронд харьцангуй тогтвортой байсан. КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эрүүл мэндийн зардал нэмэгдсэн нь энэхүү үзүүлэлтэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэн 2021 онд 2.5 нэгж хувиар нэмэгдэж 7.2 хувь, 2022 онд 8.9 хувьд хүрч өссөн байна. Гэсэн хэдий ч 2021-2022 онд инфляцын түвшин дунджаар 13.5 хувь байсан нь эрүүл мэндийн зардлын бодит өсөлтийг тухайн хэмжээгээр бууруулж байна.

Зураг 1.2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь




Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Дотоодын нийт бүтээгдэхүүнд төрийн албан ёсны санхүүжилтийн эх үүсвэр³ (улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан)-ээр санхүүжүүлсэн эрүүл мэндийн зардлын эзлэх хувь⁴ 2016-2020 онд 2.1-2.6 хувийг эзэлдэг байсан бол 2021 онд энэ үзүүлэлт нэмэгдэж 4.2 хувьд хүрсэн ба 2022 онд өмнөх оноос 1.1 нэгж хувиар буурч 3.1 хувьд хүрсэн байна.

³ “Төрөөс” гэдэгт төрийн албан ёсны санхүүжилтийн эх үүсвэр болох улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санг хамруулсан болно.

⁴ ДЭМБ-аас ДНБ-ний 5.0 хувь болон түүнээс дээш хувийг төрөөс эрүүл мэндийн салбарт зарцуулж байгаа тохиолдолд хүн ам эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй санхүүгийн дарамтгүй авах боломжтой гэж үздэг.

Зураг 1.2.2 Эрүүл мэндийн зардлын бүтэц, тэрбум төгрөг



Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 1.2.1 Эрүүл мэндийн зардал ба Дотоодын нийт бүтээгдэхүүн, тэдгээрийн жилийн өсөлт

Он	Эрүүл мэндийн зардал		Дотоодын нийт бүтээгдэхүүн		Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь
	Дүн (тэрбум.₮)	Өсөлтийн хувь	Дүн (тэрбум.₮)	Өсөлтийн хувь	
2016	1,096	-	23,931.3	-	-
2017	1,216	11	28,010.7	17	4.3
2018	1,477	22	32,582.6	16	4.5
2019	1,698	15	37,839.2	16	4.5
2020	1,779	5	37,453.3	-1	4.7
2021	3,141	77	43,555.5	16	7.2
2022	4,767	52	45,851.6	24	8.9
Дундаж өсөлт					
2016-2020		10		12	
2016-2022		30		15	

Эх сурвалж: YCX, ЭМҮТ-ны мэдээллийн сан

Эрүүл мэндийн зардал 2021 онд өмнөх оноос 77 хувиар өссөн ба цар тахлын нөлөөгөөр улсын эмнэлгүүдийн зардал 1.8 дахин, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал 1.6 дахин, хандивлагч байгууллагуудын зардал 9.4 дахин өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна. Улсын эмнэлгүүдийн зардлын өсөлтийг авч үзэхэд эм

эмнэлгийн хэрэгслийн зардал өмнөх оноос 2.5 дахин, цалин хөлстэй холбоотой зардал 1.3 дахин өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Эрүүл мэндийн зардал 2022 онд өмнөх оноос 52 хувиар өссөн нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал өмнөх оноос 1.5 дахин, хандивлагч байгууллагуудын зардал 4.0 дахин өссөнтэй холбоотой. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардал тухайн онд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тоо болон тайлангийн ирц нэмэгдсэнтэй холбоотой өссөн байна.

1.3 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал

Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 2016 онд 351 мянган төгрөг байсан бол 2022 онд 4 дахин өсөж 1.38 сая төгрөгт хүрсэн байна. 2016-2020 онд өсөлт харьцангуй тогтмол буюу нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй шууд хамааралтай өсөж ирсэн бол 2021 онд КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр өмнөх оноос 74 хувиар өссөн ба 2022 онд энэ өсөлт хадгалагдаж, өмнөх оноос 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1.3.1 Нэг хүнд ногдох ДНБ ба эрүүл мэндийн зардал



Эх сурвалж: УСХ, ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 1.3.1 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал


Он	Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал			Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн		Нэг хүнд ногдох ДНБ-д ЭМЗ-ийн эзлэх хувь
	Дүн (мянган.₮)	Өсөлтийн хувь	ам. доллар	Дүн (мянган.₮)	Өсөлтийн хувь	
2016	351	-	164	7,906	-	-
2017	382	9	157	9,043	14	4.2
2018	456	19	185	10,314	14	4.4
2019	515	13	194	11,856	15	4.3
2020	530	3	188	11,613	-2	4.6
2021	921	74	310	13,268	14	6.9
2022	1,379	50	438	15,826	19	8.7
Дундаж өсөлт						
2016-2020		10			10	
2016-2022		28			12	

Эх сурвалж: УСХ, ЭМҮТ-ны мэдээллийн сан

1.4 Эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь

Халааснаас гарах төлбөрийн эзлэх хэмжээ 2016-2018 он хүртэл жил бүр нэмэгдэж 35-44 хувьд хүрсэн. Харин 2019-2020 онд тогтмол буюу 43 хувь, 2021 онд 12 хувиар буурч 31 хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл 2021 онд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 921 мянган төгрөг байсан ба үүний 30.9 хувь буюу 284 мянган төгрөгийг иргэн халааснаасаа гаргасан байна. 2022 онд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 1,379 мянган төгрөг байсан ба үүний 38.9 хувь буюу 536 мянган төгрөгийг иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа халааснаасаа төлсөн байна.

Зураг 1.4.1 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь



Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 1.4.1 Үндсэн үзүүлэлтүүд

	ҮЗҮҮЛЭЛТ	INDICATORS	2016	2017	2018	2019	2020	2021	2022
1	Нийт эрүүл мэндийн зардал (тэрбум төгрөг)	Total Health Expenditure (THE) (billion MNT)	1,210	1,302	1,571	1,772	1,887	3,317	4,838
2	Эрүүл мэндийн зардал (тэрбум төгрөг)	Current Health Expenditure (CHE) (billion MNT)	1,096	1,216	1,477	1,698	1,779	3,141	4,767
3	Төрөөс* санхүүжүүлсэн дотоодын эрүүл мэндийн зардал (тэрбум төгрөг)	Domestic General Government Health Expenditure (billion MNT)	614	633	683	796	962	1,849	1,683
4	Дотоодын эрүүл мэндийн зардал - хувийн санхүүжилттэй (тэрбум төгрөг)	Domestic Private Health Expenditure (billion MNT)	393	476	669	758	785	987	1,917
5	Гадаад санхүүжилттэй зардал (тэрбум төгрөг)	External Health Expenditure (billion MNT)	89	106	126	144	31	305	1,167
6	Хөрөнгийн зардал (тэрбум төгрөг)	Health Capital Expenditure	114	86	94	74	108	176	71
7	Нийт эрүүл мэндийн зардалд эрүүл мэндийн урсгал зардлын эзлэх хувь	Current Health Expenditure as percent of THE	90.6	93.4	94.0	95.8	94.3	94.7	98.5
8	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь	Current Health Expenditure as percent of GDP	4.6	4.3	4.5	4.5	4.7	7.2	8.9
9	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөрөнгийн зардлын эзлэх хувь	Health Capital Expenditure as percent of GDP	0.5	0.3	0.3	0.2	0.3	0.3	0.3
10	Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар)	Current Health Expenditure per Capita in US\$	164	157	185	193	188	323	438
11	Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (мянган төгрөг)	Current Health Expenditure per Capita in (thousand MNT)	351	382	456	515	530	921	1,379
12	Эрүүл мэндийн зардалд төрөөс* зарцуулсан зардлын эзлэх хувь	Domestic General Government Health Expenditure as percent of CHE	56.0	52.1	46.2	46.9	54.1	58.4	35.2
13	Эрүүл мэндийн зардалд хувийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн зардлын эзлэх хувь	Domestic Private Health Expenditure as percent of CHE	35.9	39.2	45.3	44.6	44.1	31.9	40.3

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТООЦОО 2016-2022

14	Эрүүл мэндийн зардалд сайн дурын төлбөрийн эзлэх хувь	Voluntary Prepayments as percent of CHE	0.4	0.4	0.5	0.5	0.5	0.4	0.3
15	Эрүүл мэндийн зардалд халааснаас гарах төлбөрийн эзлэх хувь	Out-of-pocket as percent of CHE	34.9	38.1	44.0	43.2	42.7	30.9	38.8
16	Эрүүл мэндийн зардалд гадаад санхүүжилтийн эзлэх хувь	External Health Expenditure as percent of CHE	8.1	8.7	8.5	8.5	1.8	9.7	24.5
17	Улсын нэгдсэн төсвийн зардалд төрөөс* эрүүл мэндэд зарцуулсан зардлын эзлэх хувь	Domestic General Government Health Expenditure as % of GGE	6.5	7.0	7.4	6.8	6.9	11.7	9.2
18	Төрөөс* эрүүл мэндэд зарцуулсан зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Domestic General Government Health Expenditure as % of GDP	2.6	2.3	2.1	2.1	2.6	4.2	3.1
19	Төрөөс* нэг хүнд зарцуулсан эрүүл мэндийн зардал (ам.доллар)	Domestic General Government Health Expenditure per Capita in US\$	92	82	85	91	102	189	155
20	Нэг хүнд ногдох дотоодын хувийн төлбөр (ам.доллар)	Domestic Private Health Expenditure per Capita in US\$	59	61	83	86	83	102	176
21	Нэг хүнд ногдох гадаад санхүүжилт (ам.доллар)	External Health Expenditure per Capita in US\$	13	14	16	16	3	31	107
22	Нэг хүнд ногдох халааснаас гарах төлбөр (ам.доллар)	Out-of-Pocket Expenditure per Capita in US\$	57	60	81	84	80	100	170
23	Нэг хүнд ногдох халааснаас гарах төлбөр (мянган төгрөг)	Out-of-Pocket Expenditure per Capita in thousand MNT	123	146	201	223	226	285	535
24	Эрүүл мэндийн зардалд албан санхүүжилтийн эзлэх хувь	Compulsory Financing Arrangements as % of CHE	56	52	47	47	54	59	35
25	Эрүүл мэндийн зардалд улсын төсвийн санхүүжилтийн эзлэх хувь	Government Financing Arrangements as % of CHE	33	31	27	30	35	13	4
26	Эрүүл мэндийн зардалд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эзлэх хувь	Social Health Insurance as % of CHE	24	21	20	18	19	46	32
27	Эрүүл мэндийн зардалд сайн дурын санхүүжилтийн эзлэх хувь	Voluntary Financing Arrangements as % of CHE	40	44	50	50	44	31	40

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТООЦОО 2016-2022

28	Нэг хүнд ногдох анхан шатны тусламж, үйлчилгээний зардал (ам.доллар)	Primary Health Care (PHC) Expenditure per capita in US\$	21	20	27	22	31	66	41
29	Эрүүл мэндийн зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний эзлэх хувь	Primary Health Care Expenditure as % Current Health Expenditure	13	12	15	11	17	20	9
30	Төрийн* санхүүжилтэд анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувь	Domestic General Government Expenditure on PHC as %	23	24	32	24	31	35	26
Макро үзүүлэлт			Macro Values						
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум төгрөг)	Gross Domestic Product (billion MNT)	23,931.3	28,010.7	32,582.6	37,839.2	37,453.3	43,555.5	53,851.5
2	Монгол улсын нэгдсэн төсвийн зарлага (тэрбум төгрөг)	General government expenditure (billion MNT)	9,495.3	9,017.3	9,222.9	11,661.7	13,904.3	15,630.4	18,177.8
3	Гадаад валютын дундаж ханш, ам.доллар (төгрөг)	Exchange Rate (MNT per US\$)	2,147.7	2,440.6	2,472.6	2,663.9	2,813.5	2,849.3	3,144.8
4	Хүн ам (мянга)	POPULATION (in thousands)	3,119.9	3,177.9	3,238.5	3,296.9	3,357.5	3,409.9	3,457.5
5	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (мянган төгрөг)	Gross Domestic Product (GDP) per Capita in MNT	7,906.2	9,042.5	10,314.1	11,855.6	11,612.9	13,267.9	15,826.4

Тайлбар: *Төрөөс санхүүжүүлсэн гэдэг нь төрийн албан ёсны санхүүжилтийн эх үүсвэр болох улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын санг хамруулсан дүн болно.

Эх сурвалж: YCX, ЭМҮТ-ны мэдээллийн сан

БҮЛЭГ 2.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН АНГИЛАЛ




БҮЛЭГ II. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН АНГИЛАЛ

2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр

Эрүүл мэндийн зардлыг орлогын эх үүсвэрээр авч үзвэл, 2016-2022 оны дунджаар нийт санхүүжилтэд улсын төсвийн санхүүжилт (засгийн газар) 35.4 хувь, аж ахуй нэгжийн санхүүжилт 8.1 хувь, хувийн санхүүжилт (өрх, хувь хүний төлбөр) 46.4 хувь, хандивлагч төрийн бус байгууллагын санхүүжилт 9.9 хувийг тус тус эзэлж байна.

Орлогын эх үүсвэрийг авч үзвэл улсын төсвийн санхүүжилт 2022 онд 2016 оноос 2.9 дахин өсөж 1,227.0 тэрбум төгрөг, хувийн санхүүжилт 4.4 дахин өсөж 2,135.0 тэрбум төгрөг, аж ахуй нэгжийн санхүүжилт 2.4 дахин өсөж 237.6 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 2.1.1 Эрүүл мэндийн зардалд орлогын эх үүсвэрийн эзлэх хувь



Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 2.1.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрээр

Он	Орлогын эх үүсвэр (тэрбум төгрөг)					Орлогын эх үүсвэр (хувиар)				
	Засгийн газар	ААНБ	Өрх, хувь хүн	Хандивлагчид	ТББ	Засгийн газар	ААНБ	Өрх, хувь хүн	Хандивлагчид	ТББ
2016	424	98	483	89	1	38.7%	9.0%	44.1%	8.1%	0.1%
2017	443	105	560	106	1	36.5%	8.6%	46.1%	8.7%	0.1%
2018	468	121	760	126	2	31.7%	8.2%	51.4%	8.5%	0.1%
2019	589	119	844	144	2	34.7%	7.0%	49.7%	8.5%	0.1%
2020	717	114	917	31	-	40.3%	6.4%	51.6%	1.8%	-
2021	1,272	392	1,171	305	-	40.5%	12.5%	37.3%	9.7%	-
2022	1,227	237	2,135	1,167	-	25.7%	5.0%	44.8%	24.5%	-

Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан


2.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал⁵-аар авч үзвэл 2016-2022 оны дунджаар нийт зардлын 40 хувь нь бусад дотоод орлого буюу өрх хувь хүний шууд төлбөр, 24 хувь нь улсын төсвийн дотоод шилжүүлэг буюу төр хариуцах тусламж, үйлчилгээ болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг, 20 хувийг нийгмийн даатгалын шимтгэл буюу даатгалын сангийн шилжүүлэг, 10 хувийг гадаадын шилжүүлэг тус тус эзэлж байна.

2016-2019 онд хандивлагчид болон төрийн бус байгууллагын зардлын санхүүжилт харьцангуй тогтвортой буюу орлогын 8 хувийг бүрдүүлж ирсэн бол 2020 онд 6 хувиар буурч 2 хувьд хүрсэн боловч 2021 онд 9.4 хувь, 2022 онд 24.5 хувьд хүрч өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд 294.8 тэрбум төгрөгийн 54 төсөл хөтөлбөр, 2022 онд 1,167.0 тэрбум төгрөгийн 67 төсөл хөтөлбөрийг гаднаас дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн ба зардлын дүн өсөхөд Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой зардлууд голлох нөлөө үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилалд улсын төсвийн шилжүүлгийн эзлэх хувь нэмэгдэж 2020 онд 35.4 хувь байсан нь 2021 онд 38.8 хувьд хүрсэн ба даатгалын шимтгэл болон бусад орлого болох хувь хүний төлбөрийн эзлэх хувь буурсан байгаа нь цар тахалтай холбоотой эрүүл мэндийн зардлыг улсын төсвөөс шилжүүлсэнтэй холбоотой гарсан өөрчлөлтүүд байна. 2022 онд улсын төсвийн шилжүүлгийн дүн өмнөх оноос 176 тэрбум төгрөгөөр өссөн боловч нийт эрүүл мэндийн зардалд эзлэх хувийн жин нь буурч 24.3 хувьд хүрсэн нь хандивлагчдын зардал өссөнтэй холбоотой өөрчлөлт юм.

Зураг 2.2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал (хувиар)



⁵ Энэ ангиллаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт шилжих механизмыг харуулдаг.

Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хэдийгээр даатгалын шимтгэлийн эрүүл мэндийн зардалд эзлэх хувийн жин буурсан байгаа ч даатгуулагч, ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл 2016-2022 онд жилд дунджаар 14 хувийн өсөлттэй байсан ба 2022 оны дүн нь өмнөх оноос 26 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлт даатгуулагчийн тоо өссөн болон цалингийн доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Мөн 2022 онд шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн тоо өмнөх оноос 13.5 мянган хүнээр нэмэгдэж 200.8 мянган хүн болсон, аж ахуй нэгж байгууллагад ажилладаг даатгуулагчийн тоо 183.4 мянган даатгуулагчаар нэмэгдэж 749.3 мянгад хүрчээ.

Хүснэгт 2.2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх орлогын ангилал (хувиар)

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Улсын төсвийн дотоод орлогын шилжүүлэг	32.3	30.9	26.5	29.3	35.4	38.8	24.3
Гадаадын эх үүсвэртэй санхүүжилтийг улсаас хуваарилсан шилжүүлэг	0.2	0.3	0.6	0.3	0.0	0.3	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл	23.6	21.2	19.7	17.6	18.7	19.6	10.9
Сайн дурын урьдчилсан төлбөр	0.4	0.4	0.5	0.5	0.5	0.4	0.3
Бусад дотоод орлого	35.5	38.8	44.8	44.1	43.6	31.5	39.9
Гадаадын шууд шилжүүлэг	7.9	8.4	7.9	8.1	1.8	9.4	24.5

Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан


2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн ангилал

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 2016-2020 оны дунджаар улсын төсөв 31.2 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 20.2 хувь, өрх хувь хүний төлбөр 40.6 хувь, сайн дурын болон гадаад эх үүсвэрийн санхүүжилт 11.4 хувийг тус тус эзэлж байсан.

Харин нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэний дараа буюу 2021 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд улсын төсөв 13.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 45.7 хувь, өрх хувь хүний төлбөр 30.9 хувь, гадаад эх үүсвэрийн санхүүжилт 9.4 хувийг тус тус эзэлсэн.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд мөн 2022 онд улсын төсөв 3.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 31.8 хувь, өрх хувь хүний төлбөр 39.2 хувь, гадаад эх үүсвэрийн санхүүжилт 24.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бүтэц (хувиар)



Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Улсын төсвийн санхүүжилт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд голлох үүргийг гүйцэтгэсээр ирсэн ба 2020 онд түүний эзлэх хувь 35.4 хувь байсан бол 2021 онд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотой энэ үзүүлэлт буурч 13.5 хувьд хүрсэн ба 2022 онд 3.5 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Эсрэгээрээ Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 2020 онд 18.7 хувь байсан бол 2021 онд 45.7 хувь, 2022 онд 31.8 хувьд хүрч өссөн байна. Өрх, хувь хүний төлбөр 2016-2021 онд жилд дунджаар 22 хувийн өсөлттэй байсан ба түүний эрүүл мэндийн зардалд эзлэх хувь 2016-2020 онд 35-43 хувьд хүрч өссөн бол 2022 онд өмнөх оноос 8 нэгж хувиар өссөн ба мөнгөн дүнгээр 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Шигтгээ 1. Нэг худалдан авагчийн тогтолцооны тухай

Эрүүл мэндийн салбарын багц хуулиудад орсон өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн салбарт 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах улсын төсвийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, стратегийн чиг үүрэг бүхий нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх санхүүгийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр **улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан** гэсэн хоёр салангид системийг нэгтгэж тусгай зориулалтын шилжүүлгийг даатгалын санд төвлөрүүлэх болсон.

Улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн дагуу эмнэлгүүд хагас бие даасан засаглалаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж үзүүлэх тусламж, үйлчилгээний цар хүрээ, байгууллагын хүчин чадлаас хамаарсан гүйцэтгэлийн тоо хэмжээ, чанарын үзүүлэлтээр эрүүл мэндийн даатгалын сан болон хуулийн хүрээнд зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогоос санхүүгийн үндсэн эх үүсвэр бүрддэг болсон. Орлогын хэмжээнд үндэслэн зардлаа тухайн эмнэлэг өөрсдөө төлөвлөх боломжтой болж, тогтвортой ажиллахын тулд тусламж, үйлчилгээний чанарын гүйцэтгэл болон байгууллагын үр ашигт байдалд анхаарах шаардлагатай болж өөрчлөгдсөн.

Хүснэгт 2.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн ангилал (тэрбум төгрөг)

АНГИ-ЛАЛ	ТОДОРХОЙЛОЛТ	2016	2017	2018	2019	2020	2021	2022
1	Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сан	616.2	636.9	691.5	802.3	962.3	1,859.0	1,683.3
1.1	Улсын төсөв (Нийгмийн халамжийн сангаас бусад)	357.2	379.1	400.0	504.2	630.4	423.2	166.5
1.2	Эрүүл мэндийн даатгалын сан	259.0	257.8	291.5	298.1	331.9	1,435.7	1516.7
2	Сайн дурын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөр	98.3	116.1	136.7	162.5	52.8	312.1	1227.0
2.1	Сайн дурын эрүүл мэндийн даатгал	5.0	5.6	9.0	11.5	20.9	17.2	20.7
2.2	Ашгийн бус байгууллагын санхүүжилт	49.5	60.8	77.3	96.7	0.0	0.0	0.0
2.NEC	Сайн дурын болон гадаад санхүүжилт /ангилагдаагүй/	43.8	49.7	50.4	54.3	31.9	294.8	1193.5
3	Өрх, хувь хүний төлбөр	381.6	462.5	649.2	733.2	763.9	969.5	1,867.9


Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

2.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төрлөөр

Эрүүл мэндийн зардлыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төрлөөр авч үзвэл 2016-2022 оны дунджаар дараах байдлаар гарсан байна. Үүнд:

- Бүх төрлийн ортой эмнэлэг болох төрийн болон хувийн хэвшлийн ортой эмнэлэг - 46 хувь;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэгчид болох эмийн сан, эм ханган нийлүүлэх төв, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх байгууллага - 26 хувь;
- Удирдах байгууллагууд болох ЭМЯ болон харьяа агентлаг, төвүүд, аймаг, нийслэлийн ЭМГ - 6 хувь;
- Амбулаторийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага- 5 хувь;
- Туслах үйлчилгээ эрхлэгч болон урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага- 2 хувь;
- Урт хугацааны тусламж, үйлчилгээ эрхлэх байгууллагууд болох сэргээн засах төв болон рашаан сувиллын үйлчилгээ эрхлэгч байгууллагууд гарсан зардал 1 хувь;
- Бусад буюу хандивлагч байгууллагууд, гадаадад эмчилгээ хийлгэсэн иргэдийн зардал – 12 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2.4.1 Эрүүл мэндийн зардал, тусламж, үйлчилгээ эрхлэгч байгууллагаар (хувиар)



Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 2.4.1 Эрүүл мэндийн зардал, байгууллагын төрлөөр (тэрбум төгрөг)

АНГИЛАЛ	ТОДОРХОЙЛОЛТ	2016	2017	2018	2019	2020	2021	2022
1	Эмнэлэг	576.3	578.0	592.2	763.3	729.3	1,521.8	1,599.6
1.1	Нэгдсэн эмнэлэг	371.6	386.9	444.7	531.2	475.2	1,210.5	925.0
1.1.1	Улсын нэгдсэн эмнэлэг	368.3	379.6	400.4	484.8	457.9	1,128.5	878.8
1.1.1.1	Төв эмнэлэг	72.0	70.3	74.4	90.7	19.2	152.6	196.3
1.1.1.2	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	32.9	34.7	36.7	45.6	54.0	127.8	90.3
1.1.1.3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	93.5	93.7	98.9	120.7	134.2	224.5	222.8
1.1.1.4	Хөдөөгийн эмнэлэг	5.1	5.6	5.8	7.2	16.6	0.4	0.5
1.1.1.5	Дүүргийн нэгдсэн эмнэлэг / дүүргийн эрүүл мэндийн нэгдэл	42.3	49.2	54.6	68.7	77.4	130.7	168.8
1.1.1.7	Сум дундын эмнэлэг	15.8	16.7	17.3	22.9	25.5	21.2	26.3
1.1.1.8	Сум тосгоны эрүүл мэндийн төв	106.7	109.4	112.8	128.9	131.0	471.7	174.2
1.1.2	Хувийн хэвшлийн нэгдсэн эмнэлэг	1.9	5.8	42.8	44.5	15.1	78.3	33.8
1.1.NEC	Бусад нэгдсэн эмнэлэг	1.5	1.5	1.6	1.9	2.2	3.7	12.4
1.2	Сэтгэцийн эмнэлэг	10.2	10.3	10.4	12.0	13.1	13.6	19.6
1.3	Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг (сэтгэцийн эмнэлгээс бусад)	194.5	180.8	137.0	220.1	240.9	297.7	655.0
1.3.1	Улсын төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг (сэтгэцийн эмнэлэг болон хорт зуршлын эмнэлгээс бусад)	94.3	123.5	132.7	155.7	174.3	259.6	330.7
1.3.1.1	Төрөлжсөн мэргэжлийн төв	60.4	73.4	79.6	92.7	103.0	177.0	202.2
1.3.1.2	Амаржих газар	29.3	42.9	45.6	53.1	60.0	69.9	119.5
1.3.1.NEC	Улсын төрөлжсөн мэргэжлийн эмнэлгээс бусад (сэтгэцийн эмнэлэг болон хорт зуршлын эмнэлгээс бусад)	4.7	7.2	7.5	10.0	11.3	12.7	9.1
1.3.2	Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэжлийн төв (сэтгэцийн эмнэлэг болон хорт зуршлын эмнэлгээс бусад)	100.2	57.3	4.4	64.3	66.6	38.1	324.2
2	Урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага	14.6	15.4	18.3	10.4	30.2	33.7	74.2
3	Амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага	24.3	32.4	95.6	50.4	153.7	162.6	214.3
3.1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч клиник эмнэлэг	18.5	26.2	88.3	40.5	141.5	151.9	128.3
3.2	Шүдний амбулатори	5.7	6.2	7.3	9.9	12.3	10.8	82.5
4	Туслах үйлчилгээ үзүүлэгч байгууллага	12.9	16.1	21.8	24.4	28.3	30.7	95.0
4.1	Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага	6.7	7.1	7.2	8.0	9.3	11.5	16.0
4.2	Эмнэл зүйн болон оношилгооны лаборатори	5.9	8.5	14.2	16.4	18.2	19.3	77.9

4.9	Туслах үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллага	0.3	0.5	0.4	0.0	0.8	-	1.2
5	Жижиглэн худалдаа эрхлэгч болон эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэгч байгууллага	262.2	337.1	384.0	429.9	527.5	779.7	1,102.0
6	Урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний байгууллага	2.6	5.2	7.6	8.8	3.0	12.0	2.9
7	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, санхүүжилт	51.6	54.5	57.9	68.0	149.1	246.3	102.5
8	Бусад	49.5	60.8	77.3	96.7	0.0	-	-
9	Гадаадын байгууллага	97.6	110.9	215.1	236.3	147.5	340.6	1,510.7
NEC	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага /ангилагдаагүй/	4.5	5.1	7.5	9.9	10.4	13.1	65.6

Эх сурвалж: ЭМҮТ-ны мэдээллийн сан

Хүснэгт 2.4.2 Эрүүл мэндийн зардал, байгууллагын төрлөөр (хувиар)

